1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	28,077.9	88,457.2
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,077.9	77,498.3
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	10,959.0
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Сумын төсвийн төвлөрүүлэн захирагч Засаг дарга Ш.Айбек танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Энэхүү тайланд сумын Засаг даргын сангуудын хариуцсан албан тушаалын чиг үүргийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2021 оны 3 дугаар сарын 16-аас 2022 оны 03 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022 оны 03 дугаар сарын 21-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын аудитор Б.Үүрийнтуяа гүйцэтгэв.

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 1/27 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хуулиар хүлээлгэсэн нийтлэг бүрэн эрх, үүргээ хэрэгжүүлэхийн төлөө бүх хүчин чадал, ур чадвар, хуримтлуулсан туршлагаа дайчлан чин шударгаар ажиллан, тэргүүний эвсэг, шилдэг хамт олон бүрдүүлэх” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Иргэний нийгэм, төрийн байгууллагын түншлэл, ил тод байдал, хариуцлагын тогтолцоо нь хуулиа дээдэлсэн, төрийн үйлчилгээ нь нээлттэй, шуурхай хүнд суртал, чирэгдэлгүй, ёс зүйтэй, ажил хэрэгч, иргэдийн санал хүсэлтийг хүндэтгэсэн байх

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас 2021 онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад үр нөлөөтэй байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2608.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 26.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 20.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 45.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 51.3 сая төгрөг болж, 6.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Банканд байгаа бэлэн мөнгө	45.0	51.3	6.3	14.0
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
Дүн	45.0	51.3	6.3	14.0

Эх сурвалж: Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд 51.3 сая төгрөг байгаагаас 26.0 сая төгрөг нь сумын орон нутгийн ерөнхий орлогын дансанд, 15.2 сая төгрөг нь ОНХСангийн, 10.1 сая төгрөг нь СХСангийн дансны үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт:

Тус сумын ТШЗ-ийн тайлангаар мөнгөн хөрөнгөтэй холбоотой алдаа зөрчил гараагүй байна.

3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 210.4 сая, эцсийн үлдэгдэл 309.6 сая төгрөг болж, 99.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.2	0.1	-0.1
Төлбөртэй үйлчилгээний авлага		73.8	73.8

Татаас, санхүүжилтийн авлага			-
Зээлийн хүүгийн авлага	7.3	9.1	1.8
Бусад авлага	3.5	26.0	22.5
Зээлийн авлага	199.4	200.6	1.2
Дүн	210.4	309.6	99.2

Эх сурвалж: Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай авлага байхгүй байна.

Сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдэл 209.7 сая төгрөг байгаа нь нийт авлагын 67.7 хувийг эзлэж, тайлант онд авлагын эргэн төлөлтөөс нэмж зээл олгосноор авлага нэмэгдсэн байна. Зээлийн хүүгийн авлага 1.8 сая төгрөгөөр өссөн байна.

Төсөвт байгууллагуудаас сумын Эрүүл мэндийн төвийн Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийн авлага 73.8 сая төгрөгийн, Хүүхдийн цэцэрлэгийн тоног төхөөрөмж худалдан авахад шилжүүлсэн авлага 15.0 сая төгрөгийн, Төсөл сангаас Эргэлтийн эмийн сангийн эмийн авлага 11.0 сая төгрөгийн авлага шинээр нэмэгдсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн тайланд Аймгийн Засаг даргын 2021 оны А/1075 тоот захирамжаар төсөвт хийсэн зохицуулалтаар Эд хогшил, урсгал засварын зардалд багаж, техник, хэрэгсэл авахад суулгасан 15.0 сая төгрөгийг “Ернур” ХХК-д техник хэрэгсэл худалдан авахаар шилжүүлж, хөрөнгийг орлого авч бүртгэснийг үндсэн хөрөнгөөс хасаж, авлагад тусгуулан залруулга хийлээ.

3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 164.1 сая, эцсийн үлдэгдэл 176.7 сая төгрөг болж, 12.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	23.3	28.2	4.9
Хангамжийн материал	140.8	148.5	7.7
Дүн	164.1	176.7	12.6

Эх сурвалж: Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл 176.7 сая төгрөг болж 12.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд сумын төсөвт байгууллагууд төсвийн хөрөнгөөр 234.5 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 21.0 сая төгрөгийн материал үнэгүй хүлээн авч данс бүртгэлд тусгаж, үйл ажиллагаандаа 232.5 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 10.4 сая төгрөгийг акталсан байна.

Бараа материалын нийт үлдэгдлийн 78.6 сая төгрөг нь Ерөнхий боловсролын сургуулийн, 24.6 сая төгрөг нь Хүүхдийн цэцэрлэгийн, 51.8 сая төгрөг нь Эрүүл мэндийн төвийн, 21.7 сая төгрөг нь орон нутгийн байгууллагуудын үлдэгдэл байна. Сумын ЭМТ-ийн материалын үлдэгдэл өмнөх оноос нэмэгдсэн шалтгаан нь тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотойгоор худалдан авсан, үнэгүй хүлээн авсантай холбоотой материалын үлдэгдэл нэмэгдсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Сумын ЭМТөв нь ажилчдад тэтгэмжид олгосон 21.5 сая төгрөгийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.

Сумын бусад төсөвт байгууллагуудаас тайлант онд бараа материалтай холбоотой зөрчил дутагдал гараагүй байна.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 6074.1 сая, эцсийн үлдэгдэл 6546.0 сая төгрөг болж, 472.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	6016.7	6488.7	472.0
Биет бус хөрөнгө	57.3	57.3	0.0
Дүн	6074.1	6546.0	472.0

Эх сурвалж: Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 14.9 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 521.2 сая төгрөгөөр нэмэгдсэн, 64.1 сая төгрөгийн хөрөнгө акталсан байна. Дуусаагүй барилга дансанд хөрөнгө бүртгээгүй байна.

Аудитын илрүүлэлт:

Сумын төсөвт байгууллагуудын тайлангаар үндсэн хөрөнгийн данстай холбоотой зөрчил дутагдал гараагүй байна.

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 38.7 сая, эцсийн үлдэгдэл 44.0 сая төгрөг болж, 5.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг	23.3	0.5	-22.8	1.2
Бараа үйлчилгээний зардлын өглөг	10.7		-10.7	0.0
Байгууллагад төлөх өглөг	0.8	43.5	42.7	98.8
Хувь хүмүүст төлөх өглөг	3.9		-3.9	0.0
Нийт дүн	38.7	44.0	5.3	100.0

Эх сурвалж: Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн жилийн эцсийн үлдэгдэл 44.0 сая төгрөгийн 98.8 хувийг буюу 42.7 сая төгрөгийг байгууллагад төлөх өглөг, 1.2 хувийг буюу 0.5 сая төгрөгийг хувь ажилчидтай холбоотой өглөг эзэлж, бараа үйлчилгээний зардлын өглөг, хувь хүмүүст төлөх өглөгийг бүрэн барагдуулсан байна.

Өр төлбөр дансанд тайлант оны өглөг нэмэгдсэн шалтгаан нь оны эцэст сумын ЭМТ-ийн ЭМДС-аас авах авлага холбоотой гарсан 29.5 сая төгрөгийн, ЭЭС-ийн 8.6 сая төгрөгийн, сумын ОНХС-ийн ажлын гүйцэтгэл дуусаагүй он дамжсан төсөл арга хэмжээний санхүүжилтийн олгоогүй өглөгүүд эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

Сумын төсөвт байгууллагуудын тайлангаар өглөгтэй холбоотой зөрчил дутагдал гараагүй байна

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4971.4 сая, эцсийн үлдэгдэл 5352.7 сая төгрөг болж, 420.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Засгийн хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/ бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2496.1	2496.1	0	46.6
Хуримтлагдсан үр дүн	-704.3	-284.3	-420.0	-5.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3140.9	3140.9	0	58.7
Дүн	4932.7	5352.7	420.0	100.0

Эх сурвалж: Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 5352.7 сая төгрөг болж 420.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны өөрчлөлт ороогүй байна. Хуримтлагдсан үр дүн -284.3 сая төгрөг болж 420.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5.10. Орлогын данс

Алтанцөгц сум нь 2021 онд гүйцэтгэлээр орон нутгийн орлогоос 60.4 сая төгрөгийн орлого оруулж, тусламж санхүүжилтийн орлогоор тусгай зориулалтын шилжүүлгээс 1762.2 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 758.1 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 95.4 сая төгрөгийн, нэмэлт санхүүжилтээр 88.5 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 80.6 сая төгрөг оруулан, үнэ төлбөргүйгээр 542.2 сая төгрөгийн хөрөнгө, бараа материалыг хүлээн авч, нийтдээ 3387.4. сая төгрөгийн орлого бүрдүүлэн ажилласан байна.

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт орлого 3387.4 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 849.4 сая төгрөгөөр буюу 33.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан төсвийн урсгал, нэмэлт санхүүжилт, орон нутгийн төсөв, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө, бараа материал, ЭМД-ын сангийн санхүүжилт байна.

3.5.11 Зардлын данс

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт зардал 2851.2 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 242.7 сая төгрөгөөр буюу 9.3 хувиар өссөн байна.

Нийт зардлын 97.9 хувь нь бараа үйлчилгээний зардал, 2.1 хувь нь урсгал шилжүүлэг байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс, НДШ, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, эд хогшил, урсгал засварын зардал, томилолт, зочны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлгийн зардлууд 0.9-102.8 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тайлант онд Алтанцөгц сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 2685.6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2559.7 сая төгрөгийг урсгал зардалд, 125.9 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1762.1 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 717.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 114.3 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас, 22.2 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 70.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэл

Алтанцөгц сум нь 2021 онд гүйцэтгэлээр нийтдээ 2673.1 сая төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого бүрдүүлснээс тусгай зориулалтын шилжүүлгээс 1761.9 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 705.4 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 21.6 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 114.3 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 69.9 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 69.9 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн нь Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орсон орлого байна.

Нийт санхүүжилтээс 0.2 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн ба орон нутгийн төсвөөс 11.6 сая төгрөгийн, ЭМДС-гаас 0.6 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авч, үндсэн үйл ажиллагааны орлого 0.07 сая төгрөгөөр тасарсан үзүүлэлттэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2665.6 сая төгрөг буюу 99.3 хувьтай байгаа нь төвлөрүүлсэн болон дутуу авсан санхүүжилт, тасарсан орлоготой холбоотой байна.

Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар:

Аймгийн ИТХ-ын 2020 оны “Орон нутгийн төсөв батлах тухай” 16 дугаар тогтоолоор Алтанцөгц сумын 2021 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 34.7 сая төгрөгөөр баталж, Аймгийн ИТХ-ын хуралдааны “2021 оны төсөвт тодотгол хийх тухай” 2021 оны 41 дүгээр тодотголоор 34.7 сая төгрөгөөр хэвээр нь баталсан байна.

Сумын ИТХ-ын 2021 оны 21 дүгээр хуралдааны тогтоолоор 2021 орлогын төлөвлөгөөг 34.7 сая төгрөгөөр хэвээр нь баталжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогод 60.4 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөөг 25.8 сая төгрөгөөр буюу 74.3 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №7 Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл				/сая төгрөг/	
Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өсөлт/+/ бууралт /-/	Дүнд эзлэх хувь	
I.Татварын орлого	33.4	53.2	19.8	88.1	
II.Татварын бус орлого	1.3	7.2	5.9	11.9	
Нийт дүн	34.7	60.4	25.7	100.0	

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд татварын орлогоос үйл ажиллагааны орлогын албан татвар 3.6 сая төгрөгөөр, иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогоос суутгасан албан татвар буюу хөрөнгийн орлого 2.5 сая төгрөгөөр, бууны албан татвар 1.2 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 0.03 сая төгрөгөөр, газрын төлбөр 2.3 сая төгрөгөөр, ойн нөөцийн төлбөр 1.9 сая төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр хураамж 0.04 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Орон нутгийн орлогын төлөвлөгөөний давж биелэгдэхэд хүү торгуулийн орлого 2.2 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлого 2.1 сая төгрөгөөр давж биелэгдэн, төлөвлөгөөгдөөгүй агнуурын нөөцийн төлбөрөөс 29.3 сая төгрөгийн, бусад нэр заагдаагүй орлогоос 3.6 сая төгрөгийн орлого оруулсан нь орон нутгийн орлого давж биелэгдэхэд голлон нөлөөлсөн байна.

Сумын Засаг даргын 2021 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн “Идлэг шонхор шувуу бариулах” тухай Катар улсын иргэнтэй байгуулсан гэрээний дагуу төлөвлөгөө өгөгдөөгүй агнуурын нөөц ашигласны төлбөрийн 27.3 сая төгрөгийн, “Мармара интернэйшнл” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу ан агнуулах ангийн урьдчилгаа төлбөрөөс 2.0 сая төгрөгийн орлого оруулсан байна. Ан агнуулах орлого нь Ковид-19 цар тахалтай холбоотой хийгдээгүй урьдчилгаа орлого оруулсан байна.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 27.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба Орон нутгийн орлогын 995 тоот дансаар 60.4 сая төгрөгийн татварын орлого оруулж, оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 25.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт №8 Төсвийн байгууллагуудын 2021 оны төсвийн зарлагын гүйцэтгэл:

/сая төгрөг/

Д/д	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	Сумын ИТХ	43.2	43.2	-
2	Сумын ЗДТГ	345.2	345.2	-
3	Ерөнхий боловсролын сургууль	1,225.9	1,225.7	0.2
4	Хүүхдийн цэцэрлэг	351.3	351.3	0.0
5	Соёлын төв	102.8	102.8	-
6	Эрүүл мэндийн төв	421.2	420.5	0.6
7	ОНХСан	125.9	110.7	15.2
8	СХС	70.0	66.0	4.0
	Нийт дүн	2,685.6	2,665.6	20.0

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 77.5 сая төгрөгийн, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 11.0 сая төгрөгийн, нийт 88.5 сая нэмэлт санхүүжилт хүлээн авсан байна.

Үүнээс цалин хөлстэй холбоотой зардалд 52.6 сая, гэрэл цахилгаанд 0.2 сая, тээвэр шатахууны зардалд 5.3 сая, эмийн зардалд 12.1 сая, хоолны зардалд 1.2 сая, багаж техник, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж зардалд 0.2 сая,

бараа үйлчилгээний бусад зардалд 12.6 сая төгрөгийн, нийтдээ 88.3 сая төгрөгийг зарцуулж, 0.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого ороогүй байна

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Алтанцөгц сумын Засаг дарга нь 2021 онд нийт 3069.5 сая төгрөгийн 79 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 3069.5 сая 75 мэдээллийг хугацаанд ил тод байршуулж, 2 мэдээллийг хоцроосон байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус ТТЗ-ийн багцад хамаарах 6 байгууллагыг хамруулан, мөн хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг шалгалаа.

Тухайн ТТЗ-ийн багцад хамаарах 1 байгууллага нь 2021 онд нийт 205.7 сая төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 4.0 сая төгрөгийн 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна. Иймд 1 байгууллагад зөвлөмж өгч ажиллалаа.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид төлбөрийн акт, албан шаардлага өгөгдөөгүй, зөвлөмж өгөгдөөгүй байна.

Хүснэгт: №8 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		/сая төгрөг/ Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт							
Албан шаардлага							
Зөвлөмж							
Нийт							

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 4 тусгайн сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 байгууллага, нэгжийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас Засаг даргын тамгын газар, Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна. Сумын ИТХ, Соёлын төв, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, Эргэлтийн эмийн сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж үзсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар алдаа зөрчил гараагүй байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой залруулга гараагүй байна.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлантай холбоотой алдаа зөрчил илрээгүй, акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 42.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн тайланд 15.0 сая төгрөгийн залруулга хийгдэж, Ерөнхий боловсролын сургуульд 1.9 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага, Эрүүл мэндийн төвд 25.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 3 зөвлөмж өгөгдлөө.

Хүснэгт 8: Төсөвт байгууллагуудын алдаа зөрчлийн нэгтгэл /сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Алтанцөгц сумын Ерөнхий боловсролын сургууль	1	1.9					1	1.9		
2	Хүүхдийн цэцэрлэг	1	15	1	15.0						
3	Алтанцөгц сумын Эрүүл мэндийн төв	2	25.5							2	25.5
Нийт дүн		4	42.4	1	15.0	-	-	1	1.9	2	25.5

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

1. Албан тушаалын чиг үүргийн хэрэгжилттэй холбоотой асуудал:

1.1. Илрүүлэлт:

Сумын Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн 2 дугаар гарын үсгийг Засаг даргын тамгын газрын нягтлан бодогч зурж, тайлан баланс гаргаж ирүүлсэн байна.

Энэ нь Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 42 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Санхүүгийн албаны даргын ажлын байрны тодорхойлолтын албан тушаалын 2 дугаар зорилтын 12, 3 дугаар зорилтын 1-д заасныг зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 42 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан сумын Санхүүгийн албаны ажлын байрны тодорхойлолтод заасны дагуу Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангуудын 2 дугаар гарын үсгийг санхүүгийн албаны даргаар зуруулж, тайлан, баланс гаргуулах зөрчлийг арилгаж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

/сая төгрөг/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Алтанцөгц сумын ТТЗСНТайлан	1	0							1	